



ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ

Хүндэт эцэг эх/асран хамгаалагчид аа,

Virginia-ийн Боловсролын хэлтсээс Гэр бүлийн боловсролын сургалтыг явуулах эсэх нь орон нутгийнхны шийдэх асуудал- түүнчлэн уг сургалтыг зайнаас эсвэл виртуал маягаар явуулах эсэхээ мөн тэд шийднэ хэмээн сургуулиудад мэдээлээд байна. 2020-2021 оны хичээлийн жил нь бүрэн хэмжээний зайны сургалт хэлбэрээр эхлэх гэж байгаатай холбогдуулан Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиас Гэр бүлийн боловсролын сургалтын стандартын шинэчилсэн хувилбарыг гарган хянаж, виртуал хэлбэрийн сургалтад тохирох стандартуудыг тодорхойлохоор ажиллаж байна. Эдгээр сэдвүүдийн зарим нь сэтгэцийн эрүүл мэнд, үерхэл, нөхөн үржихүй, бэлгийн замын өвчин зэргийг хамрах болно. Эдгээр Сургалтын стандартуудын талаарх мэдээллийг эцэг эх/асран хамгаалагчдад АТӨС-ийн вэб сайт дахь Сургуулийн Ярианы цагаар дамжуулан энэ намар хүргэх болно.

Арлингтоны Сургуулийн Зөвлөл нь Гэр бүлийн боловсролын хөтөлбөрийн агуулгын зарим сэдвийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөх болно. Энэхүү хөтөлбөр нь гэр бүлийн үнэт зүйл, харилцааны нормтой зөрчилдөх зорилго агуулаагүй болно. Хэдийгээр Гэр бүлийн боловсролын хөтөлбөр нь хүүхдээ хүмүүжүүлэхэд нь эцэг эхэд туслах, тэднийг дэмжихэд зориулагдсан боловч зарим эцэг эх тодорхой зорилгоор хүүхдээ энэхүү сургалтаас чөлөөлүүлэхийг хүсэж болно. Хүүхдээ Гэр бүлийн боловсролын сургалтаас чөлөөлүүлэхийг сонгосон эцэг эх сургалтаас гаргах маягыг дараах сайтаас татан авна уу.

- АТӨС-ийн дараах вэб хуудсаас татаж авна уу.
[https://www.apsva.us/healthphysicalanddrivereducation/family-life-education/;](https://www.apsva.us/healthphysicalanddrivereducation/family-life-education/)
- Сургууль дээрээс:
- 703-228-6165-Аар Эрүүл Мэнд болон Биеийн Тамирын албатай холбогдон авч болно.

Эцэг эх хүүхдээ зарим хичээлээс гаргахыг хүсвэл, тэдэнд оронд нь өөр даалгавар өгөх болно. Сургууль бүр дээр эцэг эхийн мэдээлийн хурал (виртуал) явагдах болно. Уг сургалтын материалын болон эцэг эхчүүд энэхүү сургалтын хүрээнд хүүхдээ гэртээ хэрхэн дэмжин ажиллах талаарх мэдээллийг энэхүү хурлаар хүргэх болно.

Арлингтоны Төрийн Өмчит Сургуулиуд дараах зорилгын хүрээнд хүүхдийн насны онцлогт тохирсон, цогц (цэцэрлэгээс 10-р анги хүртэл) Гэр бүлийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорьж байна.

- Өөрийн талаарх эерэг ойлголт бий болгох болон бусдыг хүндэтгэх;
- Гэр бүл болон эргэн тойрныхонтойгоо бат бэх харилцаа холбоо тогтоох;
- Өөрийгөө хүндлэх, өөртөө итгэх болон хариуцлагатай болох;
- Бэлгийн харилцаанд орохгүй байхын ач холбогдлыг ойлгох;
- Стрессээ зохицуулж, үе тэнгийнхнийхээ дарамтыг давж гарах;
- Сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдлэг олж авах;
- Бэлгийн хүчирхийлэл болон буруу үерхэлээс урьдчилан сэргийлж, буруу харилцааг таньж мэдэх болон;
- Хариуцлагатай, үр бүтээлтэй, дасан зохицох чадвар өндөртэй хүн болон төлөвших;

Гэр бүлийн боловсролын хөтөлбөр болон хүүхдээ уг сургалтаас чөлөөлүүлэх хүсэлтийн маягтыг онлайнаар дараах хуудаснаас авч болно. <https://www.apsva.us/healthphysicalanddrivereducation/family-life-education/>.

Хэрвээ эдгээр материалын хуулбарыг шуудангаар авахыг хүсвэл хүүхдийнхээ сургуулийн Эрүүл мэнд болон Биеийн Тамирын албаны 703-228-6165 утсаар холбогдоно уу. Хэрвээ танд асуулт байвал хүүхдийнхээ багш, захирал эсвэл надтай 703-228-6165 утсаар холбогдох буюу deborah.defranco@apsva.us хаягаар электрон шуудан явуулаарай.

Дебора ДеФрэнко, Эрүүл Мэнд, Биеийн Тамир болон Атлетикийн тэнхимийн эрхлэгч